

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ААН-ийн нэр	“БМНС” ХХК
Төслийн нэр	Өлзийт тээлийн алтны шороон орд
Байршил	Архангай аймгийн Цэнхэр сум
Хаяг	Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 27 – р хороо, 21-р хороолол, Толгойт гудамж 16 тоот
Холбоо барих	Утас: 976 – 99005803 E-mail: uurkhai@gmail.mn
Хариуцах хүн	Байгаль орчны мэргэжилтэн С.Мөнхбат Утас: 94444610

Өлзийт тээлийн алтны шороон ордод анх 1998-1999 онуудад “Монгол газар” ХХК эрэл, хайгуулын ажил хийж ордын нөөцийг С₁, С₂ зэргээр тогтоосон байдаг. Улмаар ордод олборлолтын үйл ажиллагааг 1999 оноос эхлэн 2008 он хүртэл “Монгол газар” ХХК болон “Алтан дорнод Монгол” ХХК олборлолтын ажлыг явуулсан байна.

2008 оноос Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль батлагдсантай холбогдуулан тус ордод олборлолт явуулах боломжгүй болсон бөгөөд 2016 оноос дээрх хуулийн дагаж мөрдөх журмаар олборлолт явуулж эхлэсэн болно.

2015 оны 11 сарын 02-ны өдрийн АМГ-ын Кадастрын хэлтсийн даргын 952 тоот шийдвэрээр MV-001410 тоот тусгай зөвшөөрлийг “Бат бродерс” ХХК-аас “БМНС” ХХК-д шилжүүлсэн байна.


2015 онд “БМНС” ХХК MV-001410 тоот тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авах үед өмнөх компаниудын үйл ажиллагааны улмаас 280 гаруй га талбай уурхайн нөлөөлөлд өртсөн байдаг. “БМНС” ХХК 2016 оноос тус тусгай зөвшөөрлийн талбайд үйл ажиллагаа явуулахад 38 га талбай уурхайн нөлөөлөлд өртсөн байна. Манай компани 2016 оноос нөхөн сэргээлтийн ажлыг шат дараалалтайгаар гүйцэтгэж 2025 оны эцсийн байдлаар 215.1 га талбайд техник, 131.6 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг зохих стандартын дагуу гүйцэтгэж орон нутагт хүлээлгэн өгөөд байна.

Төслийн байршил

MV-001410 тоот тусгай зөвшөөрлийн талбай нь засаг захиргааны хувьд Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт байрлана. Улаанбаатар хотоос баруун урагш 500 км, Архангай аймгийн Цэнхэр сумаас урагш 70 км тус тус зайтай оршино. Цэнхэр сумаар Монгол улсын хэвтээ тэнхлэгийн Улаанбаатар-Архангай чиглэлийн хатуу хучилттай авто зам дайран өнгөрдөг. Талбайн номенклатур М-47-48, ордын байрлалыг дараах зурагт үзүүлэв.

Ордын байршил

Зураг. 1



Ордын байршилын сансрын зураг

Зураг. 2



Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

Архангай аймаг

Архангай аймаг нь 55 мянган хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй 19 сум, 99 багтай. Хамгийн том газар нутагтай сум болох Ихтамир сум нь 4.8 мянган км² нутаг дэвсгэртэй бол аймгийн төв Эрдэнэбулган сум нь 0.5 мян.км² буюу хамгийн жижиг газар нутагтай юм.

Хүн ам:

Архангай аймаг нь 96.7 мянган хүн амтай, 27.8 мянган айл өрхтэй. Нийт хүн амын 49.9 хувь нь эрэгтэй, 50.1 хувь нь эмэгтэйчүүд тус тус байна.

Дэд бүтэц:

Аймгийн хэмжээнд 1083 аж ахуй нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас ХАА, агнуурын чиглэлээр 114, боловсруулах чиглэлээр 104, барилгын чиглэлээр 34, бөөний болон жижиглэн худалдааны чиглэлээр 325 гэх мэт олон чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Архангай аймаг нь төвийн эрчим хүчний систем, хатуу хучилттай авто замд холбогдсон, өндөр хурдны шилэн кабел, тоон системийн радио шугам, хөдөлгөөнт холбооны үйлчилгээтэй, нийтийн хямд тээврийн хэрэгсэлтэй, хүмүүсийн амьдралын өртөг багатай зэрэг давуу талуудтай.

Эдийн засгийн байдал:

Архангай аймгийн эдийн засгийн үндсэн салбар нь мал аж ахуй бөгөөд сүүлийн жилүүдэд газар тариалан, аялал жуулчлал, уул уурхай эрчимтэй хөгжиж байна. Архангай аймаг хангайн бүсийн жуулчдын нэгэн чухал зорих газрын нэг болсноор тус аймгийн нутагт одоогоор 24 жуулчны бааз, 5 зочид буудал, 1 аялал жуулчлалын цогцолбор, 2 рашаан сувилал үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн хэмжээнд бүх сумд төвлөрсөн эрчим хүчний системд холбогдсон ба аймгийн нутаг дэвсгэрт Mobicom, Skytel, Unitel, G-Mobile болон цахилгаан холбооны үүрэн телефонтой.

Цэнхэр сум

Цэнхэр сум нь Хангайн уулархаг муж хийгээд Орхон, Тамирын хөндийд оршдог бөгөөд хойд талаараа Эрдэнэбулган, Батцэнгэл сумтай баруун, баруун урд талаараа Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, өмнөд талаараа Өвөрхангай аймгийн Бат- Өлзий, Бүрд сумтай, зүүн өмнө зүүн талаараа өөрийн аймгийн Төвшрүүлэх, Хотонт сумтай хиллэн оршино. Нутаг дэвсгэрийн хувьд 332.8 мянган га талбайтай. Цэнхэр сумын нийт 5.4 мянган хүн амтай, 152 мянган толгой малтай, Улаанбаатар-Архангай

чиглэлийн хатуу хучилттай авто зам дайран өнгөрдөг, 35 кВт-н цахилгаан дамжуулах агаарын шугамд холбогдсон дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн сум юм.

Цэнхэр суманд 12 жилийн дунд сургууль, хүн, мал эмнэлгийн салбар, цэцэрлэг, соёл урлагийн цогцолбор, халуун ус, үсчний газар, худалдаа үйлдвэр үйлчилгээний цэгүүд, газар тариалангийн чиглэлийн компани, хоршоо, нөхөрлөл, ХААН Банк, холбооны салбар зэрэг аж ахуй нэгж тус тус ажилладаг байна.

1.1 Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг багасгах, арилгах талаар хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9	
1	Агаарын чанар								
1	Тоосжилт болон бохирдуулагчийн нөлөөгөөр орчны агаар бохирдох, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Уурхайн технологийн замыг усалж чийглэх, (тодорхой ажлын график гаргах ба хуурайшилттай үед усалгааны хугацааг ойртуулах)	Элс болон хөрс тээврийн зам	км	75.0	60 удаа	4.5	2026 он хуурайшилттай үед	ЗТБХБ-ын сайдын 2011 оны 216 тоот тушаал. MNS4585:2007
2		Уурхайн замуудад хайрга чулуу дэвсэх зэргээр технологийн замыг сайжруулж тоос босохоос хамгаалах	Элс тээврийн зам	км					
3		Уурхайн талбайд ажиллах авто тээврийн хэрэгслийн хурдыг /40км/ боломжит хэмжээгээр хязгаарлах арга хэмжээ авах	Төслийн хүрээнд	-	-	-	-	2026 он өдөр бүр	-
4		Уурхай дотор замыг тэмдэгжүүлж, засаж сайжруулж байх	Төслийн хүрээнд	Ширхэг	-	-	1.0	2026 он	Агаарын тухай хууль 9, 11, 23-р зүйл MNS 4585:2007 MNS 5919:2008
		Хүнд механизм утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах талаар засвар үйлчилгээг тогтмол явуулах. Хөдөлгүүрээс гарах утааны найрлага стандартад заасан хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд шүүлтүүр, гүйцэд исэлдүүлэх хэрэгсэл	Төслийн хүрээнд, уурхайд ажиллаж буй бүх хүнд механизмуудад	-	1000.0			ҮАЗ	2026 он

Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт орших “Өлзийт тээлийн алтны шороон орд”-ын 2026 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9	
5		төхөөрөмж тавих /TWCAT002, TWCAT0061 маркийн шүүлтүүр/	Төсөлд ашиглагдах бүх авто машин	Ширхэг	-	тээврийн хэрэгсэл	-	2026 он	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
		Хүнд даацын машин механизмын засвар үйлчилгээг тогтмол явуулах, (бусад уурхайн жишгийн дагуу 200 мото/цаг)							
6	Тоосжилт хүний эрүүл мэндэд нөлөөлөх	Уурхайн карьер, овоолгод ажиллаж байгаа ачих буулгах, тээвэрлэх машин техникийн кабин доторх агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч байх	Төсөлд ашиглагдах бүх авто машин	Ширхэг	500		ҮАЗ	2026 он	ХАБЭАТ хууль
		Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүнсний нэмэлт болон хордлого тайлах бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах;	Тоосжилт ихтэй хэсгүүдэд ажилдаг ажилчид	-	-		ҮАЗ	2026 он	MNS 5080:2023 MNS 6768 : 2019 MNS 0012-13:91
2	Гадаргын ба газрын доорх усны нөөц								
1	Газрын доорх усанд орчны хомстол үүсэх	Ус ашиглах гэрээг байгуулах	Төслийн хүрээнд	-	-	-	ҮАЗ	2026 он	Усны тухай хууль 31.2 зүйл Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
2		Ус ашиглах дүгнэлтийг холбогдох байгууллагаар гаргуулах.	Төслийн хүрээнд		-	-	ҮАЗ		
3		Ус ашигласан төлбөрийн улирал бүр төлж байх	Төслийн хүрээнд		-	-	ҮАЗ		
4		Хаягдал усны дүгнэлт	Төслийн		-	-	ҮАЗ	2026 он	

Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт орших “Өлзийт тээлийн алтны шороон орд”-ын 2026 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
		гаргуулж ажиллах	хүрээнд						Усны тухай хуулийн 24.2-р заалтын
5	Усан орчин бохирдох	Усанд агуулагдах хүнд металлын шинжилгээг хийлгэж байх	Төслийн хүрээнд		-	-	ҮАЗ	2026 он	
6		Элс угаан баяжуулахад ашиглагдаж буй эргэлтийн усан санг жил бүр засаж сайжруулж лаг шаврыг зөөвөрлөж байх.	Төслийн хүрээнд		-	-	ҮАЗ	2026 он	
7	Газрын доорхи усны горим, нөөцөд сөргөөр нөлөөлж усны түвшин буурч болзошгүй	Ил уурхайн дэргэд газрын доорхи усны түвшин, чанарын өөрчлөлтийг хянах мониторингийн цооног байгуулах	Мониторингийн цооног байгуулах	-		-	3.98	2026 он	Усны тухай хууль
8	Төслийн хэрэгцээнд ашиглах боломжит усны нөөцөөс хэтрүүлэн хэрэглэхгүй байх	Төслийн хэрэгцээнд ашиглаж буй усны зарцуулалтыг хэмжих зорилгоор ашиглаж буй усны эх үүсвэрт мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан тоолуур тавих	Гүний худаг	ширхэг	300.0	1.0	0.3	2026 он	БОНХС-ын А-156-р тушаал “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”
3	Хөрсөн бүрхэвч								
1	Хөрс сийрэгжих, үржил шим алдагдаж доройтох	Ашиглалтын үед хуулсан үржил шимт хөрсний овоолгыг нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу ашиглах, шимт хөрсний овоолгыг удаан хадгалахгүй байх.	Шимт хөрсний овоолго	мян.м3	-			2026 он тухай бүрт	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль MNS 5916:2008
2	Шатах тослох материал, шатахуун асгарах	Машин механизмын эвдрэл гарсан тохиолдолд засвар үйлчилгээг хайрган	Засварын талбайд	-	-			2026 он	MNS 3307:1991, MNS

Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт орших “Өлзийт тээлийн алтны шороон орд”-ын 2026 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
3	зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	хучилттай талбайд хийх							3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга
		Ашиглагдсан тос тосолгооны материал, шатахуун асгарах, гоожих зэрэгт хяналт тавьж ажиллах, асгарсан тохиолдолд саармагжуулах арга хэмжээ авах	Ашиглалтын талбайд	-	500.0			2026 он	
4		Хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	Уурхайд ажилладаг тээврийн хэрэглэлийн жолооч, операторуудад	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2026 он	
4	Ургамалан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах								
1	Уурхайн болон ажилчдын хотхоны үйл ажиллагааны улмаас ургамлан бүрхэвч доройтох	Уурхайн тосгоны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх 2-3 эгнээ мод, бут тарих	АМТЗ-ийн талбайд	ш	2000.0	-	2.0	2026 он	Байгалийн ургамлын тухай MNS 5918: 2022.
	Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	Махчин шувуудын үүр оромж, ангуучлах нутаг, тэдгээрийн идэш тэжээл бологч амьтдын элбэгшил, байршил нутаг зэргийг харгалзан хиймэл үүр барьж өгөх	Төслийн талбай түүний ойролцоо		-	-	Үйл ажиллагааны зардал	2026 он	
		Нийт					11.78		

1.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 2. Нөхөн сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилго	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	
Техникийн нөхөн сэргээлт								
1	Техникийн нөхөн сэргээлт	Шимт хөрс хуулалт, хадгалах	га	-	4.0	Үйл ажиллагааны зардлаар	2026 он	”Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага /MNS 5917-2008/
2		Олборлолтын үйл ажиллагаа явуулсан талбайд дотоод овоолгоор нөхөн дүүргэлт хийх	га	-	6.0		2026 он	
3		Хэлбэлжүүлжүүлэх, хажууг налуулах	га	-	10.0		2026 он	
4		Шимт хөрсөөр хучилт хийх	га	-	12.0		2026 он	
Биологийн нөхөн сэргээлт								
1	Биологийн нөхөн сэргээлт	Нэг болон олон наст ургамлын үр тариалах	га	5.0	9.0	45.0	2026 он	”Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага” /MNS 5918-2023/
2		Тусгай зөвшөөрлийн талбайд навчит мод тарих	га	5.05	1.0	5.05	2026 он	
Нийт						50.05		

1.3 Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Хүснэгт 3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
1	Зэрлэг ан амьтан ундаалах уст цэгийг хамгаалах	Төслийн талбайн ойролцоо орших булгийн эхийг хашиж хамгаалах, ундарга, усны чанарыг тогтмол хянаж ажиллах	АМТЗ-ийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд	Ар улаан чулуут Булаг Ухаагийн амны булаг	3000.0	2.0	2026 он	Усны тухай хууль
2	Уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөр зэрлэг амьтад дайжих, амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх	Зэрлэг амьтдын амьдардаг гол тархац нутаг, уст цэг орчимд хужир шүү, тэжээл тавих, өвөл хаврын хуурайшилт ихтэй үед усан хангамжийг сайжруулах зэргээр биотехнологийн арга хэмжээг орон нутгийн захиргаатай хамтран зохион байгуулах	Төслийн үйл ажиллагаа явагдаж буй газар нутгийн орчимд Хангай нуурын байгалийн цогцолбор газарт	-	1000.0	1.0	2026 он	
		Үржүүлж буй зэрлэг гахайг тусгай хамгаалалтай газар нутагт байгуулж ойролцоо нутагт тогтвортой байршуулан нутагшуулах судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэх			-	-	4.0	2026 он
3	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд: Улсын чанартай автозам дагуу Хотонт сумын нутагт байрлах 1 га талбайд тарьсан 1000 ш моддод хийгдэх арчилгаа	Нийт моддод усалгаа, арчилгаа, нөхөн тарилтын ажлыг хийж гүйцэтгэх	Архангай аймгийн Хотонт сум	-	-	2.4	2026 он	
	Нийт					9.4		

1.4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 4. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүд

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9	
Ахуйн хог хаягдал									
1	Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын нөлөөгөөр хөрс, ус, агаар бохирдох, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин ашигладаг тогтолцоог нэвтрүүлэх	Төслөөс гарах хог хаягдал	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2026 он	БОАЖСайдын А/349 дугаар тушаалын
2		Ахуйн хог хаягдлын гэрээг Цэнхэр сумын ЗДТГ газартай байгуулах	Төслийн хүрээнд	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2026 он	Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоол
3		Төслийн талбайд үүссэн бүх хатуу хог хаягдлыг цуглуулж нэгдсэн цэгт хүргэж устгах	Төслөөс гарах хог хаягдал	-	1500.0	-	1.5	2026 он	Хог хаягдлын тухай хууль
4		Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, оффис, агуулах, ШТС зэрэг газарт байрлуулах, засварлаж байх	Төслийн хүрээнд	-	100.0	-	0.5	2026 он	Хог хаягдлын тухай хуулийн 15-р зүйл
5		Хог хаягдал түр хадгалах цэгийн талбайг нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах	Төслийн хүрээнд		-	-	Үйл ажиллагааны зардал	2026 он	Хог хаягдлын тухай хууль
6		Хийсэж тархсан болон үүссэн хог хаягдлын овоолгыг тогтмол цэвэрлэж хэвших	Ашиглалтын талбай болон түүний ойр орчимд	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2026 оны сар бүр тогтмол	Хог хаягдлын тухай хууль
7		Дахин ашиглах боломжтой ахуйн гаралтай хатуу хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх ажлыг тогтмол хэрэгжүүлэх	Төслийн хүрээнд	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2026 он сар бүр тогтмол	Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоол

Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт орших “Өлзийт тээлийн алтны шороон орд”-ын 2026 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын менежментийн төлөвлөгөө

8	Бие засах газар ахуйн бохир усны нөлөөгөөр байгаль орчин бохирдох	Бие засах газар, бохир усны цооногийг тогтмол ариутгаж, халдваргүйжүүлж байх	Уурхайн бие засах газар бүрийг	-	100.0	-	1.0	2026 он Дулааны улиралд тогтмол	Хог хаягдлын тухай хууль	
Аюултай хог хаягдал										
11	Тээврийн хэрэгслээс гарах аюултай хог хаягдал	Ашиглагдсан тос, тосолгооны материал, аккумуляторыг тусгай цэг гарган хуримтлуулах, түр хуримтлуулах цэгийг тохижуулах	Засварын талбайд	-				Үйл ажиллагааны зардал	2026 он	Хог хаягдлыг тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017-05-12
12		Ашигласан тос тосолгооны материалыг дахин боловсруулах үйлдвэрт улиралд нэг удаа нийлүүлэх, гэрээ байгуулах	Төслийн хүрээнд	-				Үйл ажиллагааны зардал	2026 он	
13		Хөрс шагах тослох материалаар бохирдсон тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулах арга хэмжээ авах	Төслийн хэмжээнд	-	-	-		Үйл ажиллагааны зардал	2026 он	
14		Аюултай хог хаягдлын зэрэглэлээс хамааран хог хаягдлын цэгт хамгаалалтын бүс хашаа,	Хог хаягдал түр хадгалах цэгүүдэд					Үйл ажиллагааны зардал	2026 он	

Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт орших “Өлзийт тээлийн алтны шороон орд”-ын 2026 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын менежментийн төлөвлөгөө

		хашлага татах. Хамгаалалтын бүсийн бүрэн бүтэн байдлыг хангах, хог хаягдлуудыг эмх цэгцтэйгээр байршуулах, тэмдэг тэмдэглэгээ байршуулах							
14	Хог хаягдлын бүртгэл мэдээлэл хөтлөх	Хог хаягдлын нэгдсэн бүртгэлийг хөтлөх. Хог хаягдлын бүртгэл, баталгаажуулалтыг үргэлжлүүлэн гүйцэтгэх. Хог хаягдалтай холбоотой бүх төрлийн мэдээллийг баримтжуулж, мэдээллийн сан үүсгэж байх. Баримтжуулалтын хүрээнд дараах үндсэн мэдээллийг хөтлөх Хог хаягдлын төрөл Хог хаягдлын хэмжээ Огноо Хог хаягдлын хэрхэн ангилсан Хог хаягдлыг хэрхэн зайлуулсан тухай	Төслөөс гарах хог хаягдал	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2026 он	
15	Бохирдсон зүү тариур, боолтоор халдвар дамжих, тархах	Эмнэлгийн хог хаягдлыг сумын төвийн эмнэлгийн мэргэжлийн байгууллагаар устгуулах	Гэрээ байгуулах	-	-	-	Үйл ажиллагааны зардал	2026 он	Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоол
Нийт							3.0		

1.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

Уурхайн эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллагыг зайлшгүй нүүлгэх шаардлагатай болсон тохиолдол нь “Ашигт малтмалын тухай” хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцахаар заасан байдаг.

Төсөл хэрэгжүүлэгч нь “БМНС” ХХК нь ашигт малтмал ашиглалтын MV-001410 тоот тусгай зөвшөөрөлтэй “Өлзийт тээл” нэртэй алтны шороон ордын үйл ажиллагаанаас цаашид нүүлгэн шилжүүлж, нөхөн олговор олгох шаардлага гарвал харилцан тохиролцоо замаар шийдвэрлэнэ.

Хүснэгт 5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Уурхайн ойр, орчим болон нөлөөллийн бүсэд нутаглаж амьдардаг иргэд	Шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох	АМТЗ-ийн талбай болон нөлөөллийн бүсийн айл өрх	-	-	Харилцан тохиролцооны үндсэн дээр	2026 он	“Ашигт малтмалын тухай” хуулийн 41 дүгээр зүйл
Нийт						-		

1.5 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

“Өлзийт тээл” нэртэй алтны шороон ордын олборлолтын явцад археологи, палеонтологи, түүх, соёлын дурсгалт зүйлс илэрвэл уулын ажлыг зогсоон сумын ЗДТГ, мэргэжлийн зохих байгууллагад яаралтай мэдэгдэж, авран хамгаалах, цаашлаад нүүлгэн шилжүүлэх ажлыг гүйцэтгэнэ. Бид “Түүх соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийг сахин биелүүлэх үүднээс хэрэв уурхайлалт болон уурхайн бэлтгэл шатны барилга байгууламж, зам талбайн ажлыг хийж байх үед газрын гүнээс түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл уулын ажлыг зогсоон сумын ЗДТГ, мэргэжлийн зохих байгууллагад яаралтай мэдэгдэж, авран хамгаалах, цаашлаад нүүлгэн шилжүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

Хүснэгт 6. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	АМТЗ-ийн талбай орчим болон дотор байх түүх соёлын өвүүд	Олборлолтын үйл ажиллагаанд түүх соёлын өвүүд илэрвэл	Шаардлагатай тохиолдолд дурсгалуудыг шилжүүлэх	-	-	-	2026 он	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
Нийт						ҮАЗ		

1.6 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, тэсрэх бодисын эрсдэлийн үнэлгээний дүнд тогтоосон аюултай болон хортой химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийг аюулгүй хадгалах, ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг энд тусгасан болно.

Хүснэгт 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Байгалийн болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, дам нөлөөллөөр хүрээлэн буй орчныг бохирдуулах	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Төслийн нийт ажилчдад	2.0	2.0	2026 он	ХАБЭА
2		“Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ”- мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх	Төслийн хэрэгжих нийт хугацаанд	Үйл ажиллагааны төсөвт суулгах	Үйл ажиллагааны турш	3Г-ын 2020 оны 190-р тогтоол	
3		“Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ”-г үндэслэн “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө” боловсруулан батлуулж, мөрдөн ажиллах, ажилтан бүрийн ажил үүргийн хуваарийг гаргаж, зааварчилга өгөх.	Төслийн хэрэгжих нийт хугацаанд	Үйл ажиллагааны төсөвт суулгах	Үйл ажиллагааны турш	Гамшгаас хамгаалах хууль	
4							
5	Шатах тослох материалын хадгалалт, ашиглалтаас хүний эрүүл мэнд ба хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх	Шатах тослох материалыг стандартын шаардлага хангасан агуулахад хадгалах	Төсөлд ашиглагдах машин техник	ҮАЗ	2026 он	Химийн хортой ба аюултай бодисын тухай хууль, холбогдох журам, стандарт	
6		Шатах тослох материалын хор аюулын лавлах мэдээллийн агуулгаар сургалт хийх	Нийт ажилчид 105 хүн	ХАБЭА зардал	2026 он		
7	Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах төлөвлөлтийг хийх, хэрэгжүүлэх	Нийт ажилчид 105 хүн	ХАБЭА зардал	2026 он	MNS4990:2000 Гамшгаас хамгаалах хууль	

Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт орших “Өлзийт тээлийн алтны шороон орд”-ын 2026 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
8	насанд сөргөөр нөлөөлж, олборлолтын үйл ажиллагаа доголдох, зогсох	Ажилчин нэг бүрийг хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгслээр хангах	Нийт ажилчид 105 хүн	ХАБЭА зардал		2026 он	
9		Ажилчин нэг бүрт ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалсан хор тайлах зорилгоор нормын сүү, цагаан идээгээр хангах	Хүнд нөхцөлд ажиллаж байгаа ажилчдад	Үйл ажиллагааны зардлаар		2026 он	
10		Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	-	Үйл ажиллагааны зардлаар		2026 он	
Нийт					2.0 +ҮАЗ+ ХАБЭА зардал		

1.7 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж энэ чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож, байгаль орчны асуудлыг хариуцсан ажилтандаа хариуцуулан ажиллана. Байгаль орчны асуудал нь зөвхөн байгаль орчны ажилтан, мэргэжилтнүүд анхаарал хандуулах биш захирлаас эхлээд тогооч, цэвэрлэгч, жолооч гээд уурхайн бүхий л ажилтнуудын анхаарал хандуулах чухал асуудал юм.

Хүснэгт 1.8 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, сая.төг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024-2028 он				
			Сар 1.2.3.	Сар 4.5.6.7,8	Сар 9.10.11		
1	2	3	4	5	6	7	
1	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг хийлгэх/5 жил тутамд/	Гэрээний үндсэн дээр				Уурхайн байгаль орчны ажилтан Уурхайн дарга	Газрын тухай хуулийн 58-р зүйл
2	Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх; Гарсан дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах;/2 жил тутамд/	Гэрээний үндсэн дээр					Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 101
3	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ Байгаль орчны асуудлыг удирдлагын түвшний ажилтанд хариуцуулж, хяналт тавин ажиллах; Ажилтнуудад байгаль орчны сургалтуудыг ажлын байранд нь зохион байгуулах	1.0		x		Уурхайн байгаль орчны ажилтан Уурхайн дарга	
4	Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба тайлан боловсруулах	Үйл ажиллагааны зардал	x			Уурхайн байгаль орчны ажилтан	БОНБУ-ний тухай хууль
5	Нийт зардал	1.0					

1.8 Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, төсөл хэрэгжих орчинд амьдардаг, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн амьжиргаа, нийгмийн болон эрүүл мэндийн байдлыг илтгэх гол үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамжийг тодорхойлон оруулж төлөвлөсөн болно.

Төслийг хэрэгжүүлэхэд баримтлан ажиллах орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр нь төсөл хэрэгжих орчны байгалийн болон нийгэм-эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, төслийн сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа, хяналтын байгууллагад бодитой мэдээлэл өгөх зорилготой.

Жил бүр тухайн жилд хийгдсэн хяналт-шинжилгээний үзүүлэлтүүдийг анхааралтай судалж байх нь цаашид байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, байгаль орчин болон тухайн нутагт амьдардаг иргэдийг сөрөг нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг илүү үндэслэлтэй болгох юм. Нөгөө талаас ОХШХ-г улам боловсронгуй болгох хяналтын цэгийн байршил оновчтой эсэх, объектийг бүрэн хамарч буй эсэхийг хянахад чухал ач холбогдолтой байх болно.

Уурхайн үйл ажиллагаанд хийгдэж байгаа хяналт-шинжилгээний зорилго нь уурхайн үйл ажиллагааны үед гарах хаягдал болон бусад төрлийн бохирдуулагчдыг алдагдах нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, оновчтой үзүүлэлтүүдийг сонгон авч хянах, урьдчилан харах бололцоогүй гэнэтийн осол гарсан тохиолдолд түүний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ нь оновчтой болгоход чиглэгдэнэ.

Хяналт-шинжилгээний үр дүнг нэгтгэн, жил бүр холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, сумын холбогдох албадад хүргүүлнэ.

“БМНС” ХХК нь зохих журмын дагуу (ОХШХ)-г амжилттай хэрэгжүүлэх үүднээс мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

Дээж авах, сорилт, хэмжилт хийх тоног төхөөрөмжийг зохих шаардлагын дагуу ажиллуулах, дадлагажиж, мэргэшсэн хүмүүсээр хэмжилт судалгаа хийлгэн, баримтжуулан тэмдэглэл хөтөлж, зураглал хийсэн байна.

Хяналт-шинжилгээний хэмжилтийн бүх мэдээллийг сайтар нягталж эцэслэн боловсруулсны дараа байгаль орчны мэдээллийн сан бүрдүүлэн хадгална.

Хүснэгт 9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, сая.төг	Тайлбар	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	
Агаарын чанар								
1.1	Агаар бохирдуулагчийн хэмжилт хийх	ШТМ-ын агуулах Карьерын дэргэд Элс тээврийн замын дэргэд	5-р сард 10 сард	2	-	1.0	5 цэгт хэмжилт хийх	MNS5061:2001 MNS3113:1981 MNS0017.2.5.12:8988
1.2	Дуу шуугианы хэмжилт хийх	Уурхайн тосгон Ил уурхай	Жилд 2 удаа	2				
Хөрсөн бүрхэвч								
2.1	Хөрсний ерөнхий химийн үзүүлэлтүүдийг хянах	- Нөлөөлөлд өртөөгүй талбай - Шимт хөрсний овоолго - Нөхөн сэргээлт хийгдсэн талбай	Жилд 2 удаа	2	30.0	0.54	5 цэгт хөрсний дээжлэлт хийх -	MNS 2305-94 MNS 3298-1991 MNS 5850:2008
2.2	Нефть, нефтийн бүтээгдэхүүн, хүнд металлын агууламж микробиологийн үзүүлэлт	- Шатахуун ачих, буулгах, машин механизмыг шатахуунаар цэнэглэх талбай, агуулах орчимд - Хог хаягдал бохирын цэгийн орчимд	Жилд 2 удаа	2	30.0	0.54		
3. Усан орчин								
3.1	Ундны усны микробиологийн хяналт шинжилгээ	Унд ахуйн ус	5-р сард 10 сард	1	45.0	0.54	унд ахуйн хэрэглээний усны дээжийг кемпээс	MNS0900:1992 MNS3935:1986 MNS3936:1986

Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт орших “Өлзийт тээлийн алтны шороон орд”-ын 2026 оны байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын менежментийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, сая.төг	Тайлбар	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
3.2	Усны ерөнхий химийн үзүүлэлт хүнд металлын шинжилгээ хийх	Гүний худаг Технологийн хэрэглээний ус	5-р сард 10 сард	2	45.0		авах Угаах хэсгийн усан сангаас авах	MNS4432:1997 MNS3934:1986 MNS5667-2:2001 MNS4867:1999
4. Ургамал								
4.1	Төслийн талбайн ургамлын төрөл, зүйл, тусгагын бүрхэц, арви, бүлгэмдлийн тархалт, талхагдлын зэргийг тодорхойлох	Төслийн талбайн 4-5 цэгт, сөрөг нөлөөлөлд өртөөгүй талбайд, нөхөн сэргээлт хийсэн талбайд, сөрөг нөлөөлөлд өртсөн талбайд гэх мэт	5 сар 7 сар 9 сар	2		1.0	Бүрхцийг %-иар, арвийг тоо ширхгээр, талхагдлыг их, бага дунд гэсэг үзүүлэлтээр тодорхойлох	
5. Амьтан								
5.1	Төслийн талбай болон нөлөөллийн бүсийн амьтны мониторинг хийх	Төслийн талбайн нөлөөллийн бүст 3 цэгт ажиглалт хийх	Төслийн хугацаанд	-	-	-	Төслийн хугацаанд амьтан ажиглалтын	
6. Эрүүл мэндийн хяналт								
6.1	Ажилчдын эрүүл мэнд	Нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Жилд 1 удаа	1		ҮАЗ	Эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллах	
Нийт						3.62		

1.9 БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хуваарь

БМНС” ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар орон нутгийн байгаль орчны газар, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх үүрэгтэй. Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, тогтвортой уул уурхайг дэмжих үүрэг хүлээсэн бөгөөд ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлнэ.

“БМНС” ХХК нь сум, багийн иргэдийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 10. Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа тов	Тайлагнах зардал мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1	Цэнхэр сумын багийн иргэд	ИНХ-д танилцуулах	Тухайн жилд хийгдсэн ажил	Тухайн оны 4 - р улирал	ҮАЗ	Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан	Багийн төв
2	Архангай аймгийн Байгаль орчны газар	https://eic.mn/envmng/ буюу Байгал орчны мэдээллийн санд оруулах	Тухайн жилд байгаль орчны талаар хийгдсэн ажил нөхөн сэргээсэн ажлын акт болон холбогдох материал	Тухайн оны 11 - р сарын 1 дотор	ҮАЗ	Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан	Архангай аймгийн төв
3	Төрийн захиргааны төв байгууллага	https://eic.mn/envmng/ буюу Байгал орчны мэдээллийн санд оруулах, тамгалуулах		Тухайн оны 12 - р сарын 1 дотор	ҮАЗ	Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан	Төрийн захиргааны төв байгууллага
	Нийт				ҮАЗ		

1.10 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

“БМНС” ХХК-ийн хэрэгжүүлж буй Архангай аймгийн Цэнхэр сумын нутагт орших ашигт малтмал ашиглалтын MV-001410 тоот тусгай зөвшөөрөлтэй “Өлзийт тээл” нэртэй алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал 80.85 сая байна.

Хүснэгт 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын задаргаа

№	Зардлын төрөл	Нэгж	Утга
1	Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах	сая.төг	11.78
2	Нөхөн сэргээлт	сая.төг	50.05
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах	сая.төг	9.4
4	Нүүлгэн шилжүүлэлт	сая.төг	-
5	Түүх соёлийн өв хамгаалах	сая.төг	-
6	Осол эрсдэл	сая.төг	2.0
7	Хог хаягдал	сая.төг	3.0
8	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	сая.төг	3.62
9	Удирдлага зохион байгуулалт	сая.төг	1.0
10	БОМТ тайлагнах	сая.төг	-
11	Нийт	сая.төг	80.85